# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2019 оны 12 сарын 23 өдөр　　　　Дугаар 120　　　　Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Биеийн тамир, спортын газарт шаардлагатай нийт 16,497,600 /арван зургаан сая дөрвөн зуун ерэн долоон мянга зургаан зуу/ төгрөгийн үнэтэй үндсэн хөрөнгийг хавсралтын дагуу бэлтгэж бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга /М.Наранбадрах/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА　　　　С.СҮХБААТАР

151

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугээр сарын
23.. өдрийн 120 тогтоолын хавсралт

Биеийн тамир, спортын газрын шинээр бэлтгэх
хөрөнгийн жагсаалт

| № | Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Нийт дүн | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Үнэ |
| 1 | Компьютер 3060 | ш | 2,280,000.00 | 1 | 2,280,000.00 |
| 2 | Принтер | ш | 450,000.00 | 1 | 450,000.00 |
| 3 | Компьютер | ш | 2,260,000.00 | 1 | 2,260,000.00 |
| 4 | Ширээ | ш | 300,000.00 | 3 | 900,000.00 |
| 5 | 3 хостой ширээ | ш | 380,000.00 | 1 | 380,000.00 |
| 6 | Албаны ширээ | ш | 300,000.00 | 1 | 300,000.00 |
| 7 | Хар сандал | ш | 120,000.00 | 1 | 120,000.00 |
| 8 | Хашаа | м | 74,300.00 | 132 | 9,807,600.00 |
| | Нийт дүн | | 6,164,300 /зургаан сая нэг зуун жаран дөрвөн мянга гурван зуу/ | 141 | 16,497,600 /арван зургаан сая дөрвөн дөрвөн зуун ерэн долоон мянга зургаан зуу/ |